

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 13 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 14 цаг 06 минутад эхэлж, 15 цаг 13 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 07 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none">- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга- Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Шинэтгэлийн бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн дарга	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Банзаарайн Нэргүйг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэн Банзаарайн Нэргүйг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаанд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. <p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны</p>

		<p>шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Ганболдын Чинзориг, Дуламбазарын Төмөрпүрэв нарыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газрын Шинэтгэлийн бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэдээс Ганболдын Чинзоригийг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газрын Шинэтгэлийн бодлого төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологи, инновацын хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны зарим удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга - Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга 	<p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Отгонжаргалын 2014 оны 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 3/714, 3/726 тоот албан бичгээр Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны</p>

		зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ